МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
**ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА,
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН**

ТАТВАРЫН МЭРГЭШСЭН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ: БУСАД ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Судалгааны төрөл:	**Харьцуулсан судалгаа**
Судалгааны код:	**СТ-25/247**
Хугацаа:	2025.10.27

ЗАХИАЛАГЧ:	УИХ-ын гишүүн Б.Заяабал
Хянасан:	ПСХХ–ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга Д.Онолт ПСХХ–ийн Судалгааны хэлтсийн дарга Г.Гэсэр
Судалгаа удирдсан:	Судалгааны хэлтсийн зөвлөх Б.Оюун-Эрдэнэ
Судлаач:	Судалгааны хэлтсийн ахлах референт И.Жаргалзаяабямба

Улаанбаатар хот
2025

Агуулга

Хүснэгтийн жагсаалт 2
Удиртгал 3
НЭГ. ТАТВАРЫН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ЗОХИЦУУЛАЛТ 4
1.1. Татварын зөвлөх үйлчилгээний эрх зүйн үндэс 4
1.2. Татварын зөвлөх үйлчилгээний эрх олгох нөхцөл шаардлага 5
ХОЁР. ТАТВАРЫН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО 13
2.1. Татварын зөвлөх үйлчилгээний хяналтын тогтолцоо 13
2.2. Татварын зөвлөх үйлчилгээ үзүүлэгчийн хариуцлага, сахилгын арга хэмжээ 14
СУДАЛГААНЫ ҮР ДҮН 17
НОМ ЗҮЙ i

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Улс орнуудын татварын зөвлөх үйлчилгээний эрх зүйн үндэс 4

Хүснэгт 2. Татварын зөвлөх үйлчилгээний мэргэшлийн шалгалт 6

Хүснэгт 3. АНУ-д татварын зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх бүхий этгээд, тэдгээрийн эрх хэмжээ 6

Хүснэгт 4. Улс орнуудын татварын зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх хүсэгчдэд тавигдах шаардлага 7

Хүснэгт 5. Татварын зөвлөхийн үүрэг 10

Хүснэгт 6. Зөрчил гаргасан татварын зөвлөхөд ногдуулах сахилгын шийтгэл 14

Удиртгал

Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабалын ирүүлсэн захиалгын дагуу “Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ: бусад орны эрх зүйн зохицуулалт” сэдэвт судалгааг Улсын Их Хурлын Тамгын газрын дэргэдэх Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнд гүйцэтгэв.

Судалгааны зорилго: Улс орнуудын татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний эрх олгох, сунгах, түдгэлзүүлэх болон хүчингүй болгох, мөн зөвлөх үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг, хариуцлага, хяналтын тогтолцооны талаар харьцуулан судлах.

Судалгааны хамрах хүрээ: Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний эрх зүйн зохицуулалтын талаар захиалагчаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Америкийн Нэгдсэн Улс (цаашид АНУ гэх), Европын Холбооны Улсаас Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (цаашид Герман гэх), Бүгд Найрамдах Чех Улс (цаашид Чех гэх), Азийн улс орнуудаас Япон Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс (цаашид Солонгос гэх)-ын туршлагыг судална.

Судалгааны ажлын бүтэц: Судалгааны тайлан үндсэн хоёр хэсэгтэй байна. Үүнд:

1. Татварын мэргэшсэн зөвлөхийн эрхийн зохицуулалт
2. Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний хяналтын тогтолцоо.

Судалгааны арга зүй: Судалгааг тухайн улсын холбогдох хууль тогтоомж болон олон улсын байгууллагуудаас эмхлэн нийтэлсэн судалгаа, зөвлөмж, болон бусад мэргэжлийн байгууллага, эрдэмтэн судлаачдын бүтээлд судалгааны удирдамжид заасан чиглэлийн дагуу холбогдох мэдээллийг харьцуулан судлах, нэгтгэн дүгнэх арга зүйг ашиглан гүйцэтгэв.

Түлхүүр үг: *Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ, Татварын зөвлөх, Татварын мэргэшсэн нягтлан бодогч*

Key words: *Certified Tax Advisory Service, Tax Advisory, Certified Tax Accountant,*

НЭГ. ТАТВАРЫН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ЗОХИЦУУЛАЛТ

1.1. Татварын зөвлөх үйлчилгээний эрх зүйн үндэс

Энэхүү судалгаагаар АНУ, Европын улс орнуудаас Герман, Чех улс, Азийн орнуудаас Япон болон Солонгос улсуудын татварын зөвлөх үйлчилгээний эрх зүйн орчныг зөвлөхийн эрхийн зохицуулалт, хариуцлагын тогтолцооны хүрээнд харьцуулан авч үзнэ.

Судалгаанд авагдсан улс орнуудын татварын зөвлөх үйлчилгээний эрх зүйн үндсийг судлан үзэхэд ихээхэн ялгаатай байна. Тухайлбал, АНУ-ын хувьд татварын зөвлөх үйлчилгээг эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм, журмын хүрээнд зохицуулдаг. Харин бусад дөрвөн улсын хувьд татварын зөвлөх үйлчилгээг тусгайлсан хуулиар зохицуулдаг бөгөөд тус үйлчилгээг үзүүлэхэд заавал мэргэжлийн эрх шаарддагаараа онцлог байна.

Хүснэгт 1. Улс орнуудын татварын зөвлөх үйлчилгээний эрх зүйн үндэс

Улс орнууд	Эрх зүйн үндэс	Ерөнхий зохицуулалт
АНУ	Сангийн яамнаас баталсан Дотоод орлогын албаны өмнө татварын мэргэжилтнүүдийн үйл ажиллагааг зохицуулах журам буюу 230 дугаар журам (Treasury Department Circular 230)[1]	Тус улсын Сангийн яамнаас 2014 онд Татварын мэргэжилтнүүдийн үйл ажиллагааг зохицуулах 230 дугаар журам (Circular 230)-ыг баталсан байна. Энэхүү журмаар татварын зөвлөх үйлчилгээг эрхлэгчдэд тавигдах нөхцөл шаардлага, хязгаарлалт (§§ 10.1–10.9), мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ (§§ 10.20–10.38), тэдгээрийн хүлээх хариуцлага (§§ 10.50–10.53) зэрэг бүхий л үйл ажиллагааг зохицуулсан байдаг.
Герман	Татварын зөвлөхийн тухай хууль[2], Татварын зөвлөхийн мэргэжлийн ёс зүйн дүрэм[3]	Татварын зөвлөхийн тухай хууль (Steuerberatungsgesetz – StBerG) нь 1975 оноос хэрэгжиж эхэлсэн. Тус хууль нь Холбооны болон мужийн түвшний татвар, үл хөдлөх хөрөнгийн татвар, монопол болон бусад санхүүгийн эрх зүйн хяналттай асуудлуудад татварын зөвлөх, төлөөлөгчийн туслалцааг зохицуулна (§1(1)), Татварын эрүүгийн хэргийг шийдвэрлэх, татварын бүртгэл хөтлөх, тайлан бэлтгэх, буцаан олголт (§1(2)), мөн татварын зөвлөхийн эрх олгохтой холбоотой (§1(3)) үйл ажиллагааг зохицуулсан өргөн хүрээний нарийвчилсан зохицуулалтуудыг тусгасан байдаг. Түүнчлэн Герман улсад татварын зөвлөх үйлчилгээ нь зөвхөн тусгай зөвшөөрөлтэй мэргэжилтнүүд гүйцэтгэх боломжтой хязгаарлагдмал ажил юм (European Parliament, 2022).
Чех	Татварын зөвлөгөө өгөх Чехийн Үндэсний Зөвлөл болон Татварын зөвлөхүүдийн танхимын тухай хууль[4]	Татварын зөвлөгөө өгөх Чехийн Үндэсний Зөвлөл болон Татварын зөвлөхүүдийн танхимын тухай хууль 1992 оноос хэрэгжиж эхэлсэн. Энэхүү хууль нь татвартай холбоотой асуудлаар хууль зүйн туслалцаа үзүүлэх, санхүү, эдийн засгийн зөвлөгөө өгөх, Европын хамтын нийгэмлэгийн хуулийн дагуу Чех Улсын Татварын Зөвлөхүүдийн Танхимыг

[1] АНУ. Treasury Department Circular No. 230 (2014). Хандах: https://www.irs.gov/pub/irs-pdf/pcir230.pdf
[2] Герман. Tax Consultancy Act (1975 [2024]). Хандах: https://www.buzer.de/StBerG.htm
[3] Герман. Professional Code. (Steuerberater Berufsordnung (BOStB)) (2010 [2022]). Хандах: https://www.bstbk.de/downloads/bstbk/recht-und-berufsrecht/fachinfos/BStBK_Berufsordnung-inkl-Fachberaterordnung.pdf
[4] Чех. Act of the Czech National Council on Tax Advice and the Chamber of Tax Advisers of the Czech Republic (1992 [2023]). Хандах: https://www.zakonyprolidi.cz/cs/1992-523#cast1

		байгуулах, татварын зөвлөх (§§3-8c) болон Татварын зөвлөхийн танхим (Chamber of Tax Advisers)-ийн зохион байгуулалт (§§9-11), эрх үүрэг, хяналт, ёс зүйн стандарт зэргийг зохицуулдаг.
Япон	Татварын мэргэшсэн нягтлан бодогчийн тухай хууль[5]	Тус хууль 1951 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд татвар төлөгчдөд мэргэжлийн туслалцаа үзүүлэх татварын мэргэжилтнүүдийн тогтолцоог бий болгосон. Энэ хүрээнд 1956 онд Японы татварын мэргэшсэн нягтлан бодогчдын холбоо (Japan Federation of Certified Public Tax Accountants Associations - JFCPTAA) байгуулагдсан бөгөөд улс даяар бүс нутгийн нийт 15 холбоо үйл ажиллагаа явуулдаг. Тус холбооны зорилго нь Татварын мэргэшсэн зөвлөхүүдийн холбоод болон тэдгээрийн гишүүдийг удирдан чиглүүлэх, хяналт тавих, тасралтгүй үйл ажиллагаагаа сайжруулах, хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах явдал юм (AOTCA, 2025).
Солонгос	Татварын мэргэшсэн нягтлан бодогчийн тухай хууль[6]	Солонгосын Татварын мэргэшсэн нягтлан бодогчдын тухай хууль нь 1961 оноос хэрэгжиж эхэлсэн. Тус хуулийн зорилго нь татварын мэргэшсэн нягтлан бодогчийн тогтолцоог бий болгох замаар татварын албаны хэвийн үйл ажиллагааг хангах, татвар төлөгчдийн татвар төлөх үүргээ зохих ёсоор биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх юм. Солонгосын татварын мэргэшсэн нягтлан бодогчдын холбоо нь 1962 онд байгуулагдсан бөгөөд нийт 7 бүсийн холбоо болон дүүргийн холбоодоос бүрдэнэ.

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Судалгаанд авагдсан улс орнуудын татварын зөвлөх үйлчилгээний эрх зүйн үндсийг харьцуулан үзэхэд АНУ-аас бусад улс мэргэжлийн холбоо, танхимтай бөгөөд эдгээр байгууллагуудаар дамжуулан татварын зөвлөхийн үйл ажиллагааг зохицуулж байна.

1.2. Татварын зөвлөх үйлчилгээний эрх олгох нөхцөл шаардлага

Судалгаанд хамрагдсан улс орнуудаас АНУ татварын зөвлөх үйлчилгээ үзүүлэхэд тусгай эрх заавал шаарддаггүй бөгөөд Сангийн яамны 230 дугаар журмаар татварын зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх бүхий этгээдийг тодорхойлсон байдаг. Хэдийгээр бүртгэгдсэн төлөөлөгч (Enrolled Agent) нь Дотоод орлогын алба (цаашид ДОА гэх)-ны шалгалтад хамрагдаж, татварын чиглэлээр татвар төлөгчийг холбооны түвшинд ДОА-нд бүрэн төлөөлөх эрх авдаг боловч муж улсуудад өөр өөр зохицуулалт үйлчилдэг.

АНУ-ын Үндэсний татвар төлөгчийн өмгөөлөгч (National Taxpayer Advocate)-аас 2024 онд нийтэлсэн хууль тогтоомжийн зөвлөмжид холбооны хуулиар хөлсөөр татварын тайлан бэлтгэгчдэд ур чадварын, эсхүл тусгай зөвшөөрлийн шаардлага тавьдаггүй. Ингэснээр татварын тайлан гаргах чадваргүй хүмүүс зохих хэмжээнээс илүү татвар төлөх, татварын тодорхой хөнгөлөлт эдлэх боломжгүй болгох, эсхүл татвараа дутуу тусгаснаас торгууль ногдуулах зэрэг алдаа гаргаснаар татвар төлөгчид хохирдог талаар дурджээ. Иймд татварын тайлан бэлтгэгчдэд ур чадварын шалгалт өгөх, мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөх,

[5] Япон. Certified public tax accountant act (1951 [2021]). Хандах: *https://www.nichizeiren.or.jp/eng/pdf/Zeirishi_Act.pdf* *https://hourei.net/law/326AC1000000237*?

[6] Солонгос. Certified public tax accountant act (1961 [2021]). Хандах: *https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=61428&type=part&key=20#:~:text=CHAPTER%20I%20GENERAL%20PROVISIONS*

татварын хууль тогтоомж, журмын талаар тогтмол сургалтад хамрагдахыг шаардахыг зөвлөсөн байна (National Taxpayer Advocate, 2024).

Бусад улс орнуудын хувьд татварын зөвлөх үйлчилгээний мэргэшлийн шалгалтын зохицуулалтыг хуульчилсан байна.

Хүснэгт 2. Татварын зөвлөх үйлчилгээний мэргэшлийн шалгалт

Улс орнууд	Татварын зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх бүхий этгээд	Шалгалт	
		Татварын зөвлөхийн эрх авах	Бусад
АНУ	Холбооны түвшинд: - Бүртгэгдсэн төлөөлөгч (EA) - Бүртгэгдсэн татварын тайлан бэлтгэгч	Тийм Дотоод орлогын албанаас зохион байгуулах шалгалт	-
	Мужийн түвшинд: - Мэргэшсэн нягтлан бодогч - Хуульч	Үгүй	Мужийн түвшинд мэргэжлийн холбоодын эрх олгох шалгалт
Герман Улс	Татварын зөвлөх	Тийм	-
Чех Улс	Татварын зөвлөх	Тийм	-
	Европын Холбооны гишүүн улсад татварын зөвлөхөөр ажиллах эрхтэй хүмүүст Чех улсад түр хугацаагаар зөвлөгөө өгөх эрхийг олгодог (visiting tax advisor). Гэхдээ татварын зөвлөхийн танхимд бүртгүүлсэн байх шаардлага тавьдаг (§4(4), (§8c).	Үгүй	-
Япон Улс	Татварын мэргэшсэн нягтлан бодогч	Тийм	-
Солонгос Улс	Татварын мэргэшсэн нягтлан бодогч	Тийм	-

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

АНУ-д татварын зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх бүхий этгээд нь Холбооны түвшинд Бүртгэгдсэн төлөөлөгч байх бөгөөд ДОА-аас зохион байгуулдаг шалгалтыг өгч тэнцсэн байх шаардлагатай, харин мужийн түвшинд Мэргэшсэн нягтлан бодогч, хуульчдын хувьд тухайн муж улсын мэргэжлийн холбоодын шалгалтад хамрагдаж мэргэшлийн эрх авдаг байна. Тус улсад татварын зөвлөхийн тусгайлсан эрх байдаггүй тул дээрх зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх бүхий мэргэжилтнүүдэд тавигдах Circular 230[7] журмаар зохицуулсан үндсэн шаардлага, эрх хэмжээг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 3. АНУ-д татварын зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх бүхий этгээд, тэдгээрийн эрх хэмжээ

Эрх бүхий этгээд	ДОА-нд төлөөлөх эрх	Үндсэн шаардлага
Бүртгэгдсэн төлөөлөгч (Enrolled Agent-EA)	**§10.2(a)(4)** Татвар төлөгчийн эрх, үүрэгтэй холбоотой ДОА-д хийж буй бүх	**§ 10.4(a)** Шалгалт өгч бүртгэгдсэн төлөөлөгч болох 18 ба түүнээс дээш настай дараах шаардлагыг хангасан өргөдөл гаргагчид Бүртгэгдсэн төлөөлөгч (EA)-ийн эрхийг олгоно:

[7] АНУ. Treasury Department Circular No. 230 (2014). Хандах: https://www.irs.gov/pub/irs-pdf/pcir230.pdf

	төрлийн мэдээлэл, тухайлбал, бичиг баримт бүрдүүлэх, харилцах, бичгээр зөвлөгөө өгөх, хурлаар төлөөлөх зэргийг хамарна. (бүрэн эрхтэй)	- Мэргэшлийн тусгай чадамжийг ДОА-наас зохион байгуулсан бичгийн шалгалтаар (Special Enrollment Examination - SEE) нотлох. - Мэргэжил эзэмшсэн эсвэл холбогдох нөхцөлүүдийг хангасан байх. - Ёс зүйн болон холбогдох суурь шалгалтуудыг (background check) амжилттай давсан байх. **§10.4(d)** ДОА-ны хуучин ажилтнуудыг бүртгэх Онцгой Бүртгэл: IRS-ийн Комиссар эсвэл түүний төлөөлөгч нь тухайн өргөдөл гаргагчид өмнөх ажил, техникийн туршлагаар нь Бүртгэлтэй төлөөлөгч (EA)-ийн эрхийг шалгалтгүйгээр олгох эрхтэй. Үндсэн шаардлага: Өмнөх албан тушаал, туршлага нь бүртгэлд хамрагдах шаардлагыг хангасан байх, 5-аас доошгүй жил ажилласан байх, ДОА-аас чөлөөлөгдсөнөөс хойш 3 жилийн дотор бүртгүүлэх зэрэг шаардлага тавьдаг.
Мэргэшсэн нягтлан бодогч	Мужийн түвшинд: ДОА-нд төлөөлөх бүрэн эрхтэй	**§10.2(a(2)).** Аливаа муж, нутаг дэвсгэрт Мэргэшсэн Нягтлан Бодогчоор бүртгэгдсэн, эрхийг түдгэлзүүлээгүй байх.
Хуульч (Attorney)	Мужийн түвшинд: ДОА-нд төлөөлөх бүрэн эрхтэй	**§10.2(a(1)).** муж, нутаг дэвсгэрийн хамгийн дээд шатны шүүхийн өмнө ажиллах эрхтэй, эрхийг түдгэлзүүлээгүй байх.
Бүртгэлтэй татварын тайлан бэлтгэгч	Хязгаарлагдмал эрхтэй: Зөвхөн тайлан бэлтгэхэд шаардлагатай хэмжээний техникийн зөвлөгөө өгөх. Хуулийн гүнзгий дүгнэлт хийх, татварын төлөвлөлт хийх эрхгүй.	**§ 10.4(c)** Бүртгэлтэй татварын тайлан бэлтгэгчээр томилох (Designation as a registered tax return preparer) Энэ ангиллын мэргэжилтнүүдийг Холбооны Татварын Тайлан Бэлтгэгч (Federal Tax Return Preparer) гэж нэрлэж, тэдний эрхийг Хязгаарлагдмал Практикийн (Limited Practice) хүрээнд авч үздэг. Өөрөөр хэлбэл тэд зөвхөн өөрсдийн бэлтгэж гарын үсэг зурсан тайлантай холбоотой асуудлаар татварын байгууллагад төлөөлөх эрхтэй байдаг.

Эх сурвалж: (Treasury Department, 2014)

Харин судалгаанд авагдсан бусад улсуудын хувьд татварын зөвлөх үйлчилгээг тусгай хуулиар зохицуулж, мэргэжлийн эрх авсан байхыг шаарддаг. Иймд татварын зөвлөхийн эрх олгох үйл явц болон үндсэн шаардлагыг энэ хэсэгт харьцуулан авч үзье.

Герман, Чех, Япон, Солонгос улсуудын татварын зөвлөх үйлчилгээний эрх олгох шалгалтад хамрагдах хүсэлт гаргасан иргэдэд нийтлэг шаардлага тавьдаг байна. Тухайлбал, мэргэжлийн шаардлагын хувьд ихэвчлэн эдийн засагч, эрх зүйч мэргэжлээр их дээд сургууль төгссөн байх, ажлын туршлагын хувьд татварын алба, төрийн байгууллагад тодорхой хугацаанд ажилласан байх шаардлага тавьдаг. Харин мэргэшлийн хувьд мэргэшсэн нягтлан бодогч, хуульч зэрэг мэргэшлийн сертификаттай бол зарим шалгалтаас чөлөөлөх, эсхүл шууд бүртгүүлж зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх авах зөвшөөрөл олгодог байна.

Хүснэгт 4. Улс орнуудын татварын зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх хүсэгчдэд тавигдах шаардлага

Холбогдох зохицуулалт	Эрх авахын өмнө тавигдах шаардлага	Татварын зөвлөх эрх олгох үйл явц
Герман Улс:	**§36 дугаар зүйлд Шалгалтад ороход тавигдах шаардлагыг тодорхойлсон**	**§37(2)** Татварын зөвлөхийн мэргэжлийг зохих ёсоор эрхлэх чадвартай гэдгийг нотлохын тулд татварын зөвлөхийн

Татварын зөвлөхийн тухай хууль[8]	- **§36(1).** Эдийн засаг, хуулийн чиглэлээр их, дээд сургууль төгссөн байх бөгөөд тус чиглэлээр 2-4 жилийн хугацаанд дадлагажсан байх - **§36(2).** Арилжааны сургалтын мэргэжилтнээр төгссөн, 8 жил ажилласан туршлагатай, эсхүл мэргэшсэн нягтлан бодогч/татварын мэргэжилтнээр мэргэшсэн, 6 жил ажилласан туршлагатай - татварын албаны төрийн ахлах албан хаагч/ажилтан, 6 жил ажилласан туршлагатай. (German Federal Chamber of Tax Advisers, 2023) - **§36(3).** Холбооны, муж, улсаас хариуцсан санхүүгийн байгууллагад татварын чиглэлээр 7 хоногт хамгийн багадаа 16 цаг ажилласан байх гэсэн шалгууртай	улсын шалгалтыг өгнө. Шалгалт нь бичгийн гурван хэсэг, аман шалгалтаас бүрдэнэ. Бичгийн шалгалтыг цахимаар авч болно. Шалгалтыг улс даяар нэгэн зэрэг явуулна. Бичгийн шалгалт 3 өдрийн турш үргэлжилнэ. **§§40-46 дугаар зүйл** Татварын зөвлөхийн танхим нь тухайн мужид татварын зөвлөхийг томилох эрх бүхий байгууллага байна. Тус танхим нь тухайн хүний шалгалтын дүн, мэргэжлийн болон ёс зүйн шаардлага, санхүүгийн найдвартай байдал зэргийг шалгаад шийдвэр гаргадаг. Өргөдөл гаргагч 50 еврогийн хураамжийг татварын зөвлөхүүдийн танхимд төлнө. Томилогдсон этгээд албан ёсны жагсаалтад бүртгэгдэж, Татварын зөвлөхийн эрх авна.
Чех Улс: Татварын зөвлөгөө өгөх Чехийн Үндэсний Зөвлөл ба Чех Улсын Татварын Зөвлөхүүдийн Танхимын тухай хууль[9]	**§5 дугаар зүйл. Мэргэшлийн шалгалт §5(1(a-f))** - Эрх зүйн бүрэн чадамжтай - Хуульд тусгайлан зөвшөөрөөгүй бол хориглосон чиглэлээр ажил, албан тушаал, үйл ажиллагаа эрхэлдэггүй байх - Татварын асуудалд хяналт тавих, шийдвэр гаргах эрх мэдэл бүхий төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагатай ажил эрхлэлт, үйлчилгээний болон түүнтэй адилтгах бусад харилцаагүй байх - магадлан итгэмжлэгдсэн бакалаврын зэрэг олгох хөтөлбөрийн хүрээнд дээд боловсрол эзэмшсэн байх - Мэргэшлийн шалгалт өгөх тухай өргөдөл гаргахаас өмнөх таван жилийн хугацаанд сахилгын шийтгэл, захиргааны шийтгэл аваагүй байх.	**§5 дугаар зүйлд мэргэшлийн шалгалт** Сангийн яамнаас томилогдсон шалгалтын комисс шалгалтыг зохион байгуулна. Шалгалтын агуулга санхүү, захиргаа, иргэний болон арилжааны хууль, эдийн засаг, нягтлан бодох бүртгэлээс бүрдэнэ. **§4 дүгээр зүйлд Татварын зөвлөгөө өгөх эрх** Шалгалтад тэнцсэнээр татварын зөвлөхүүдийн жагсаалтад орох хүсэлтээ өгч бүртгүүлснээр татварын зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрхтэй болно. Татварын зөвлөхөд жагсаалтад бүртгүүлсэн тухай Гэрчилгээ олгоно.
Япон Улс: Татварын мэргэшсэн нягтлан бодогчдын тухай хууль[10]	**§5 дугаар зүйл.** Татварын зөвлөхийн шалгалтад ороход тавигдах шаардлага - Хуульч (2-оос доошгүй жил ажлын туршлагатай бол шалгалтаас чөлөөлөгдөнө) - Мэргэшсэн нягтлан бодогч (2-оос доошгүй жил ажлын туршлагатай бол шалгалтаас чөлөөлөгдөнө)	**§12 дугаар зүйл.** Шалгалтыг Үндэсний татварын зөвлөлөөс жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулна. **§6 дугаар зүйл.** Шалгалтын агуулга ерөнхий хоёр хэсгээс бүрдэх бөгөөд - Хууль (татварын хууль болон холбогдох бусад хууль)

[8] Герман. Tax Consultancy Act (1975 [2024]). Хандах: https://www.buzer.de/StBerG.htm
[9] Чех. Act of the Czech National Council on Tax Advice and the Chamber of Tax Advisers of the Czech Republic (1992 [2023]). Хандах: https://www.zakonyprolidi.cz/cs/1992-523#cast1
[10] Япон. Certified public tax accountant act (1951 [2021]). Хандах: https://www.nichizeiren.or.jp/eng/pdf/Zeirishi_Act.pdf

	- Татварын алба болон ЗГ-ын тогтоолоор заасан аудит, санхүүгийн хяналт, нягтлан бодох бүртгэлд хамаарах захиргааны ажил зэрэгт 2-оос доошгүй жил ажилласан туршлагатай байх. - Мэргэжлийн шаардлага: Эдийн засаг, эрх зүйч мэргэжлээр их дээд сургууль төгссөн. - Хуульчийн шалгалтад тэнцсэн - Мэргэшсэн нягтлан бодогчийн шалгалтад тэнцсэн	- Нягтлан бодох бүртгэл **§18 дугаар зүйл.** Шалгалтад амжилттай тэнцсэнээр Татварын мэргэшсэн нягтлан бодогчдын жагсаалтад бүртгэгдэнэ. **§19 дүгээр зүйл.** Тус жагсаалтыг Татварын мэргэшсэн нягтлан бодогчдын холбоо хариуцна.
Солонгос Улс: Татварын мэргэшсэн нягтлан бодогчдын тухай хууль[11]	**§5 дугаар зүйл. Татварын мэргэшсэн нягтлан бодогчдын мэргэшлийн шалгалт** - **§5(3).** татварын мэргэшсэн нягтлан бодогчийн мэргэшлийн шалгалтын сэдэв болон шалгалтад шаардагдах бусад асуудлыг Ерөнхийлөгчийн зарлигаар тогтооно. - **§5.2.** Эсхүл татвар, санхүүгийн салбарт тодорхой хугацаанд ажилласан байх. Түүнчлэн нарийвчилсан шалгуурыг ерөнхийлөгчийн зарлигаар тогтоохоор хуульчилсан байдаг.	**§5.** Татварын мэргэшсэн нягтлан бодогчийн мэргэшлийн шалгалт нь Эдийн засаг, сангийн сайдын зохион байгуулдаг урьдчилсан болон хоёрдогч шалгалтаас бүрдэнэ. Ажлын туршлагын тодорхой шаардлага хангавал урьдчилсан шалгалтаас чөлөөлөх зохицуулалттай. **§12.** Шалгалтад тэнцсэн этгээд мэргэшүүлэх сургалтад хамрагдаж, мэргэжлийн дадлага тодорхой хугацаанд хийхийг хуульчилсан байна. **§6.** Мэргэшсэн татварын нягтлан бодогчоор бүртгүүлж, Татварын мэргэшсэн нягтлан бодогчдын холбоонд гишүүн болсноор үйл ажиллагаагаа эхлүүлнэ.

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Дээрх улс орнуудын хувьд татварын зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх олгох шалгалтыг холбогдох төрийн байгууллага болон танхим хариуцан зохион байгуулж байна. Харин шалгалтын үе шатны хувьд Герман хамгийн олон буюу бичгийн гурав, аман нэг шалгалт авдаг. Харин Солонгос улсын хувьд шалгалтад тэнцсэн этгээд мэргэшүүлэх сургалтад хамрагдаж, тодорхой хугацааны мэргэжлийн дадлага хийсний дараа татварын зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх авдгаараа бусад улс орнуудаас онцлог байна.

Түүнчлэн Германы татварын зөвлөхүүд маш өндөр мэргэшлийн шалгуур давж байж зөвлөхийн эрх авдаг. Тус улс нь татварын зөвлөхийн улсын нэгдсэн шалгалтын тогтолцоотой. Татварын зөвлөхийн шалгалт (Steuerberaterprüfung) нь Германы хамгийн нэр хүндтэй мэргэжлийн шалгалтуудын нэг бөгөөд шалгалтад орохын өмнө ихэвчлэн их сургуулийн зэрэгтэй байх, эсвэл татварын чиглэлээр практикт тодорхой жил ажилласан байх хатуу шаардлага тавигддаг талаар Европын Парламентын судалгаанд дурджээ (European Parliament, 2022).

Харин дээрх тодорхой нөхцөлүүдийг ханган татварын зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх авсан этгээдүүдийн үүргийг улс орнууд дараах байдлаар тодорхойлсон байна.

[11] Солонгос. Certified public tax accountant act (1961 [2021]). Хандах: https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=61428&type=part&key=20#:~:text=CHAPTER%20I%20GENERAL%20PROVISIONS

Хүснэгт 5. Татварын зөвлөхийн үүрэг

Татварын зөвлөх үйлчилгээ үзүүлэгч	Татварын зөвлөхийн үүрэг
АНУ. Бүртгэгдсэн төлөөлөгч, Мэргэшсэн нягтлан бодогч, хуульч	Сангийн яамны 230 дугаар журмын Дэд бүлэг В-д Дотоод орлогын албанд төлөөлөх үүрэг, хязгаарлалтыг дараах байдлаар зохицуулсан байна. **§§10.20-38 дугаар зүйл.** - ДОА-ны албан хүсэлтээр үйлчлүүлэгчийн холбогдох бүртгэл, мэдээллийг шуурхай өгөх үүрэгтэй. Гэхдээ нууц мэдээллийг өгөхөөс татгалзаж болно - Хэрэв зөвлөх нь харилцагч татварын тайландаа мэдээлэл орхигдуулсныг мэдвэл түүнийг анхааруулж, залруулахыг зөвлөх үүрэгтэй. - Зөвлөх нь бүх тайлан, баримтыг үнэн зөв, бодитой байхаар нягт шалгах үүрэгтэй. - Зөвлөх нь өөрийн болон бусдын ашиг сонирхол хооронд зөрчилдөх нөхцөлд ажиллахыг хориглоно. - Зөвлөх нь татварын тайлан, өргөдөл, мэдэгдэл, бусад бичиг баримтад үнэн зөв, үндэслэлтэй мэдээлэл тусгах үүрэгтэй. - Татварын зөвлөх нь зөвлөгөө өгөхийн өмнө тухайн асуудлыг хангалттай судалсан байх ёстой гэх мэт
Герман Улс. Татварын зөвлөх	Татварын зөвлөхийн тухай хууль[12] **§57 дугаар зүйл.** - Татварын зөвлөх, татварын төлөөлөгч нь мэргэжлээ хараат бус, бие даан хариуцлагатайгаар гүйцэтгэх, үйл ажиллагааны явцад олж авсан бүхий л мэдээллийн нууцыг чандлан сахих, мэргэжлийн ёс зүйд харшлах сурталчилгаа явуулахгүй байх үүрэгтэй; - Мэргэжлийн өндөр стандартыг баримтлан, алдаа гаргахгүй байхыг эрмэлзэх; - Мэргэжлийн мэдлэг, ур чадвараа байнга хөгжүүлж, дээшлүүлж байх; - Зөвлөх нь өөрийн болон бусдын ашиг сонирхол хооронд зөрчилдөх нөхцөлд үйлчилгээ үзүүлэхээс татгалзах. **§67 дугаар зүйл.** - Мэргэжлийн хариуцлагын даатгалд хамрагдах үүрэгтэй.
Чех улс. Татварын зөвлөх	Татварын зөвлөгөө өгөх Чехийн Үндэсний Зөвлөл ба Чех Улсын Татварын Зөвлөхүүдийн Танхимын тухай хууль[13] **§6 дугаар зүйл. Татварын зөвлөхийн эрх үүрэг** - Татварын зөвлөх нь үйлчлүүлэгчийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах эрх, үүрэгтэй. Тэрээр өөрийн итгэл үнэмшил, үйлчлүүлэгчийн зааврын дагуу шударга, хариуцлагатай ажиллаж, хууль ёсны бүх арга хэрэгслийг тууштай ашиглах, хэрэгжүүлэх үүрэгтэй. - Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээнээс татгалзах эрхтэй, - Татварын зөвлөх, түүнчлэн зөвлөх эрхээ хасуулсан этгээд татварын зөвлөгөө өгөхтэй холбогдуулан олж мэдсэн бүх баримт, мэдээллийн нууцыг хадгалах үүрэгтэй. - Зөвлөгөө өгөх хугацаанд бүрэн даатгуулсан байх

[12] Герман. Tax Consultancy Act (1975 [2024]). Хандах: https://www.buzer.de/StBerG.htm

[13] Чех. Act of the Czech National Council on Tax Advice and the Chamber of Tax Advisers of the Czech Republic (1992 [2023]). Хандах: https://www.zakonyprolidi.cz/cs/1992-523#cast1

	- Бүх бичиг баримтад зөвлөхийн нэр, гэрчилгээний дугаар, бүртгэлийн хаягийг заавал тэмдэглэх - гэрчилгээний мэдээлэлд гарсан өөрчлөлт болон зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр байгуулсан талаарх мэдээллийг Танхимд тухай бүр мэдэгдэнэ. - Танхимын дүрэмд заасан гишүүний татварыг хугацаанд нь төлж, Танхимын дүрэм болон бусад журам, шийдвэрийг сахин мөрдөх.
Япон Улс. Татварын мэргэшсэн нягтлан бодогч	Татварын мэргэшсэн нягтлан бодогчдын тухай хууль[14] **4 дүгээр бүлэг. §§30-43 зүйл. Татварын мэргэшсэн зөвлөхийн эрх үүрэг** - Татварын албаар үйлчлүүлэхдээ заавал Татварын мэргэшсэн нягтлан бодогчийн үнэмлэхээ үзүүлэх; - Татварын зөвлөх үйлчилгээ үзүүлэхдээ үйлчлүүлэгчийн татварын тайлан, мэдэгдэл зэрэг баримт бичгийг гарын үсэг, тамгаар баталгаажуулах үүрэгтэй; - Татварын албанаас хийгдэх шалгалтын мэдээллийг үйлчлүүлэгчид мэдэгдэх; - Татварын зөвлөх бэлтгэсэн бичгийн талаар санал авах, нууц хадгалах үүрэгтэй; - Хууль бус үйлдлийг засах талаар зөвлөх үүрэгтэй; - Татварын зөвлөхийн холбооны журмыг дагах, мэргэшлээ дээшлүүлэх.
Солонгос Улс. Татварын мэргэшсэн нягтлан бодогч	Татварын мэргэшсэн нягтлан бодогчдын тухай хууль[15] **§1 дүгээр зүйл. Эрхэм зорилго** - Татвар төлөгчдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах. - Татвар төлөгчдийг татвар төлөх үүргээ ухамсартайгаар биелүүлэхэд хувь нэмэр оруулах. **§2 дугаар зүйл. Татварын мэргэшсэн нягтлан бодогчдын үүрэг** Татварын зөвлөх нь татвар төлөгчөөс олгосон эрхийн дагуу дараах үйлчилгээг үзүүлнэ: - Татвартай холбоотой тайлан гаргах, татварын асуудлаар өргөдөл, хүсэлт зэргийг төлөөлж гаргах; - Татварын тодруулга хийх талаар мэдэгдэл гаргах болон татвартай холбоотой бусад баримт бичгийг бүрдүүлэх; - Татвартай холбоотой зөвлөгөө өгөх; - Орлогын албан татварын тухай хууль, Аж ахуйн нэгжийн албан татварын тухай хуулийн дагуу татвар төлөгч нь мэдүүлгээ үнэн зөв гаргаж байгаа эсэхийг шалгах; - Өөрийн нэрийг бусдад ашиглуулахгүй байх; - Татварын мэргэшсэн нягтлан бодогч аливаа үүргээ гүйцэтгэж байхдаа санаатай болон болгоомжгүйгээс хохирол учруулсан бол уг хохирлыг хариуцах баталгаа гаргах.

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар.

Улс орнуудын татварын зөвлөх үйлчилгээ үзүүлэгчдийн хуулиар хүлээсэн үүргийг харьцуулан үзэхэд нийтлэгээр тайлан мэдээллийг үнэн зөв, бодит мэдээлэлд тулгуурлан боловсруулах, зөвлөх өөрийн эрхээр өөрийн боловсруулсан баримт бичгийг баталгаажуулах, мэдлэг чадвараа тогтмол дээшлүүлэх зэрэг үүрэг тусгагджээ. Харин Герман, Чех, Солонгос

[14] Япон. Certified public tax accountant act (1951 [2021]). Хандах: *https://www.nichizeiren.or.jp/eng/pdf/Zeirishi_Act.pdf*
[15] Солонгос. Certified public tax accountant act (1961 [2021]). Хандах: *https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=61428&type=part&key=20#:~:text=CHAPTER%20I%20GENERAL%20PROVISIONS*

улсын хувьд мэргэжлийн хариуцлагын даатгалд хамрагдах үүргийг тусгаж өгснөөрөө онцлог байна.

ХОЁР. ТАТВАРЫН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

2.1. Татварын зөвлөх үйлчилгээний хяналтын тогтолцоо

Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ үзүүлэгчдэд тавих хяналтын тогтолцоо нь улс орон бүрт харилцан ялгаатай байна. Тухайлбал, АНУ холбооны түвшинд Дотоод орлогын алба (цаашид ДОА гэх), мужийн түвшинд мэргэжлийн холбоод хяналт хэрэгжүүлж байгаа бол тусгайлсан хуулиар зохицуулагддаг Герман, Чех, Япон, Солонгос улсуудад татварын зөвлөхүүдийн танхим үйл ажиллагааны хяналт, зохион байгуулалтыг хариуцан ажиллаж байна.

АНУ-ын татварын зөвлөх үйлчилгээ үзүүлэгчдэд төрийн байгууллага болон мэргэжлийн байгууллагын хосолсон хяналтыг хэрэгжүүлдэг. Холбооны түвшинд ДОА-ны Мэргэжлийн хариуцлагын газар (Office of Professional Responsibilty) нь Circular 230 журмын хүрээнд мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээнд хяналт тавьж, зөрчил гаргасан тохиолдолд хянан шалгах, сахилгын арга хэмжээ авах чиг үүргийг хэрэгжүүлдэг (журмын § 10.1(1)). Хяналт хэрэгжүүлэх гол хэрэгсэл нь PTIN (Preparer Tax Identification Number) дугаар юм. Тус дугаарыг ДОА-аас бүх төлбөртэй татварын тайлан бэлтгэгчид, бүртгэгдсэн төлөөлөгч нарт олгогдог бөгөөд үүгээр дамжуулан тайлан бэлтгэгчдийн үйл ажиллагаа, мэргэжлийн хариуцлагыг хянадаг байна (IRS, 2025). Харин мужийн түвшинд мэргэжлийн байгууллагууд буюу Нягтлан бодох бүртгэлийн үндэсний холбоо (National Association of State Boards of Accountancy) нь мэргэшсэн нягтлан бодогчдын үйл ажиллагаанд, Мужийн хуульчдын холбоо (State Bar Association) нь хуульчдад хяналт хэрэгжүүлдэг байна.

Герман Улсын хувьд Татварын зөвлөхийн тухай хуулийн §88((1)-(3))-т зааснаар Холбооны Сангийн яам болон муж улсуудын санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн дээд шатны байгууллага нь өөрийн харьяаны Татварын зөвлөхийн танхимд хяналт тавина. Ингэхдээ хууль, дүрмийн хэрэгжилтийг хангах, танхимд өгсөн үүргийн биелэлтэд хяналт тавидаг. Мөн шаардлагатай тохиолдолд хяналт хэрэгжүүлэх зорилгоор холбогдох шийдвэрийг гаргаж, арга хэмжээг авч болно гэж тусгажээ.

Харин Холбооны татварын зөвлөхүүдийн танхим нь Татварын зөвлөхийн тухай хуулийн §85а-д зааснаар улсын хэмжээний бодлого, журам гаргах, татварын зөвлөхүүдийн танхимуудыг нэгтгэн зохицуулах, нэгдсэн бүртгэл-платформыг удирдах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг. Улс даяар нийт 21 мужид Татварын зөвлөхийн танхимтай (BStBK, 2025). Тус хуулийн §76 дугаар зүйлд зааснаар танхимууд нь бүх гишүүдийнхээ мэргэжлийн ашиг сонирхлыг хамгаалах, дэмжих, тэдний мэргэжлийн үүргийн биелэлтэд хяналт тавих үүрэгтэй байна.

Чех Улсын хувьд Татварын зөвлөгөө өгөх Чехийн Үндэсний Зөвлөл болон Татварын зөвлөхүүдийн танхимын тухай хууль[16]-ийн §1.b-д Татварын зөвлөхүүдийн танхимыг байгуулахаар заасан байдаг. Түүнчлэн тус хуулийн §9 дүгээр зүйлд зааснаар Танхим нь татварын зөвлөхүүдийн нэгдсэн жагсаалтыг хөтлөх, татварын зөвлөх үйлчилгээ эрхлэх эрх олгох, сахилгын шийтгэл ногдуулах эрхийг хуульчилсан байна. Бүтэц, зохион байгуулалтын хувьд тус хуулийн §10 дугаар зүйлд зааснаар танхим нь Танхимын гишүүдийн нэгдсэн хуралдаан, Тэргүүлэгчид, Хяналтын зөвлөл, Сахилгын хороо, Шалгалтын зөвлөл, нарийн бичгийн даргаас бүрдэнэ.

Хуулийн §§12-13 дугаар зүйлд зааснаар Танхимын хяналтын хороо нь татварын зөвлөхийг зөвлөгөө өгөхдөө энэ хууль болон татварын зөвлөхийн эрх, үүргийг зохицуулсан

[16] Чех. Act of the Czech National Council on Tax Advice and the Chamber of Tax Advisers of the Czech Republic (1992 [2023]). Хандах: *https://www.zakonyprolidi.cz/cs/1992-523#cast1*

бусад актаар хүлээсэн үүргээ ноцтой буюу давтан зөрчсөнийг мэдсэн өдрөөс хойш зургаан сарын дотор, зөрчил гаргасан өдрөөс хойш гурван жилийн дотор Сахилгын хороонд санал гаргах ёстой. Харин Сахилгын арга хэмжээ ногдуулах тухай шийдвэрийг танхимын сахилгын хороо гаргаж, §12 дугаар зүйлд заасан сахилгын арга хэмжээ авахаар зохицуулагдсан байна.

Япон Улсын хувьд Үндэсний татварын алба (National Tax Agency) нь хуулийн хэрэгжилтийн хяналтыг хариуцдаг (Татварын мэргэшсэн нягтлан бодогчдын тухай хуулийн §55 дугаар зүйл) бөгөөд §12 дугаар зүйлд зааснаар Татварын зөвлөхийн эрх олгох шалгалтыг жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулахаар хуульчилсан байна. Хуулийн §55 дугаар зүйлд зааснаар Шаардлагатай гэж үзвэл Үндэсний татварын албаны комиссар татварын зөвлөхүүд болон татварын зөвлөх корпорацуудаас үйлчилгээний талаар тайлан авах, зөвлөгөө өгөх, эсхүл Үндэсний татварын албаны ажилчид, тэдгээрийн бизнесийн нөхцөл, дансны дэвтрийн баримт бичиг болон бусад зүйлийг шалгах боломжтой.

Харин Японы Татварын мэргэшсэн зөвлөхүүдийн холбоо нь татварын зөвлөхүүдийн өдөр тутмын мэргэжлийн үйл ажиллагаанд хяналт тавьдаг бөгөөд холбоо нь бүс нутгийн 15 салбар холбоогоор дамжуулан гишүүдийнхээ үйл ажиллагааны тайланг жил тутам хүлээн авч дүгнэх, гомдол санал хүлээн авах, зөрчил гарсан тохиолдолд холбогдох сахилгын шийтгэл оногдуулах ажлыг зохион байгуулдаг байна (AOTCA, 2025)

Солонгос Улсын хувьд Эдийн засаг, санхүүгийн яам нь татварын зөвлөхийн шалгалтыг зохион байгуулах, зөвлөх үйлчилгээний эрхийн зохицуулалт, холбооны үйл ажиллагааны дүрмийг хянан баталгаажуулахаар хуулиар зохицуулагдсан байдаг. Харин тус хуулийн §20.3 дугаар зүйлд хуулийн хүрээнд өөрийн хэрэгжүүлэх зарим чиг үүргийг Үндэсний татварын алба болон Татварын мэргэшсэн нягтлан бодогчдын холбоонд шилжүүлж болно гэж тусгагдсан байна.

Мөн тус хуулийн §3 дугаар зүйлд зааснаар Үндэсний татварын албанаас **Мэргэшлийн шалгалтын хороог** байгуулж, татварын мэргэшсэн нягтлан бодогчийн мэргэшил олгохтой холбоотой асуудалд хяналт тавьдаг байна. Тус шалгалтын хорооны үйл ажиллагааны дүрэм, журмыг Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоодог.

Солонгосын Татварын мэргэшсэн нягтлан бодогчдын холбоо (Korean Association of Certified Public Tax Accountants) нь Татварын мэргэшсэн нягтлан бодогчдын үйл ажиллагааг сайжруулах, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, татварын мэргэшсэн нягтлан бодогчдын удирдлага, хяналт шалгалттай холбоотой захиргааны үйл ажиллагааг хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэгтэй байна (§18(1)).

2.2. Татварын зөвлөх үйлчилгээ үзүүлэгчийн хариуцлага, сахилгын арга хэмжээ

Судалгаанд хамрагдсан улс орнууд татварын зөвлөх үйлчилгээ үзүүлэгчдэд холбогдох хууль, дүрэм, журам, мэргэжлийн хариуцлага, ёс зүйн хэм хэмжээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтэд хяналт тавьж, зөрчил үүссэн тохиолдолд хариуцлага хүлээлгэхээр зохицуулагдсан байдаг. Эдгээр улсад сахилгын шийтгэл нь нийтлэгээр сануулах, торгох, зөвлөхийн эрхийг тодорхой хугацаагаар түдгэлзүүлэх, эрхийг хасах гэсэн төрлүүдтэй байна.

Хүснэгт 6. Зөрчил гаргасан татварын зөвлөхөд ногдуулах сахилгын шийтгэл

Улс орнууд/ зохицуулалт	Хариуцлага хүлээлгэх үндэслэл	Сахилгын шийтгэлийн төрөл
АНУ. 230 дугаар журам (Treasury	**§10.52.** Шийтгэлд хамаарах зөрчил.	**§§10.50(a),(c).** - Сануулах (Censure);

Department Circular 230)[17]	(1) Аливаа дүрэм журмыг санаатайгаар зөрчсөн; (2) Болгоомжгүй эсхүл бүрэн чадваргүй (gross incompetence) байдлаас үүдэн; Мөн хөлсөөр татварын тайлан гаргагчид нь ДОА-д бүртгүүлэн, татварын бэлтгэгчийн дугаар (PTIN) авдаг ба энэ дугаарыг үйлчлүүлэгчдийн тайланд бичихийг хуульчилсан нь, цаашид алдаа зөрчил гарсан тохиолдолд тухайн бэлтгэгчийг шууд илрүүлэх, хариуцлага тооцоход чиглэгджээ.	- Эрхийг тодорхой хугацаагаар түдгэлзүүлэх; - Эрх хасах; - Мөнгөн торгууль.
Герман Улс. Татварын зөвлөхийн тухай хууль[18],	**§89(1).** Мэргэжлийн ёс зүйн дүрэм[19]-ийг санаатайгаар зөрчсөн, мөн татварын зөвлөхийн хуулиар оногдуулсан үүргийг зөрчвөл сахилгын шийтгэл оногдуулна. **§89(2).** Тухайн зөвлөхийн мэргэжлийн үйл ажиллагаанаас гадуурх үйлдэл нь хууль бус үйлдэл эсвэл захиргааны зөрчил гаргасан, мөн энэ нь мэргэжлийн нэр хүнд, итгэлцэлд ихээхэн хохирол учруулах хэмжээнд байвал мэргэжлийн үүргийн зөрчил гэж үзнэ.	**§90(1).** Татварын зөвлөх, татварын төлөөлөгчийн эсрэг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд мэргэжлийн сахилгын арга хэмжээ авна. - Анхааруулах (Warning); - Зөвлөх (Reference); - 50,000 евро (буюу ~58,115 ам доллар) хүртэл торгууль; - Мэргэжлээрээ ажиллахыг 1-5 жил хүртэл хугацаагаар хориглох; - Мэргэжлээс хасах. **§90(3).** Сахилгын шийтгэл, торгуулийн арга хэмжээг нэгэн зэрэг ногдуулж болно.
Чех Улс. Татварын зөвлөгөө өгөх Чехийн Үндэсний Зөвлөл болон Татварын зөвлөхүүдийн танхимын тухай хууль[20]	**§12(1).** Гэмт хэргээс олсон орлогыг хууль ёсны болгох, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх зарим арга хэмжээний тухай хуулиас бусад тохиолдолд татварын зөвлөх зөвлөгөө өгөхдөө энэ хууль болон татварын зөвлөхийн эрх, үүргийг зохицуулсан бусад актаар хүлээсэн үүргээ ноцтой буюу давтан зөрчсөн **§12(2).** Татварын зөвлөх нь мэдүүлэг гаргагчийн хувьд мэргэшлийн шалгалтад хамрагдах өргөдөл, эсхүл түүний зарим хэсэгт мэдсээр байж хуурамч буюу дутуу мэдээлэл өгсөн бол түүнийг энэ хуульд заасан үүргээ ноцтой зөрчсөн гэж үзнэ. **§12(3).** Сахилгын зөрчилд зөвхөн нэг сахилгын шийтгэл ногдуулж болно.	**§12(1).** Сахилгын шийтгэлийн төрлүүд - Бичгээр анхааруулах; - 100,000 крон (буюу ~4,790 ам доллар) хүртэл торгууль; - Татварын зөвлөх үйлчилгээг 1 жил хүртэл хугацаагаар түдгэлзүүлэх; - Жагсаалтаас хасах.
Япон Улс. Татварын мэргэшсэн нягтлан	**§45(1).** Татварын зөвлөх нь төлөөллийн үйл ажиллагааг эрхлэхдээ зориудаар бодит баримтаас харш татварын баримт бичиг бүрдүүлсэн, эсхүл 36 дугаар зүйлийн заалтыг	**§44 дүгээр зүйл Сахилгын шийтгэлийн төрөл** - Сануулах (Reprimand);

[17] АНУ. Treasury Department Circular No. 230 (2014). Хандах: https://www.irs.gov/pub/irs-pdf/pcir230.pdf
[18] Герман. Tax Consultancy Act (1975 [2024]). Хандах: https://www.buzer.de/StBerG.htm
[19] Герман. Professional Code. (Steuerberater Berufsordnung (BOStB)) (2010 [2022]). Хандах: https://www.bstbk.de/downloads/bstbk/recht-und-berufsrecht/fachinfos/BStBK_Berufsordnung-inkl-Fachberaterordnung.pdf
[20] Чех. Act of the Czech National Council on Tax Advice and the Chamber of Tax Advisers of the Czech Republic (1992 [2023]). Хандах: https://www.zakonyprolidi.cz/cs/1992-523#cast1

бодогчийн тухай хууль[21]	зөрчсөн үйл ажиллагаа явуулсан тохиолдолд Сангийн сайд сахилгын шийтгэл ногдуулна. **§45(2). Татварын зөвлөх** нь болгоомжгүй байдлын улмаас өмнөх хэсэгт заасан үйлдлийг санамсаргүйгээр хийсэн тохиолдолд Сангийн сайд сануулах, эсхүл зөвлөхийн үйлчилгээг хоёр жил хүртэл хугацаагаар зогсоохыг албадаж болно. **§46. Ерөнхий сахилгын шийтгэл** Татварын зөвлөх нь бэлтгэсэн тайлангийн хавсралтад хуурамч баримт хавсаргасан, эсхүл Татварын мэргэшсэн нягтлан бодогчдын тухай хууль болон үндэсний болон орон нутгийн татварын тухай хуулийг зөрчсөн бол сахилгын шийтгэл ногдуулна.	- Татварын зөвлөх үйлчилгээний эрхийг 2 хүртэл жилээр түдгэлзүүлэх; - Татварын зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрхийг хасах.
Солонгос Улс. Татварын мэргэшсэн нягтлан бодогчийн тухай хууль[22]	**§17(1).** Сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл - Татварын мэргэшсэн нягтлан бодогчдын тухай хуулийг зөрчсөн; - Солонгосын татварын мэргэшсэн нягтлан бодогчдын холбооны дүрэм журмыг зөрчсөн.	**§17(2) Сахилгын шийтгэлийн хэлбэр.** - Бүртгэлийг хүчингүй болгох; - Үйл ажиллагаа эрхлэх хугацааг хоёр жилээс илүүгүй хугацаагаар түдгэлзүүлэх; - 10 сая вон (буюу ~7,044 ам доллар)- оос хэтрэхгүй захиргааны торгууль; - Сануулах (Reprimand)

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Тухайн улсын татварын зөвлөх үйлчилгээг зохицуулсан хууль тогтоомж, дүрэм, журам, мэргэжлийн хариуцлага, ёс зүйн хэм хэмжээний хүрээнд гарсан зөрчлийг сахилгын шийтгэл ногдуулах замаар шийдвэрлэж байна. Харин Герман, Чех, Солонгос улсуудад татварын зөвлөхүүдийг мэргэжлийн хариуцлагын даатгалд хамрагдахыг шаарддаг. Энэ нь зөвлөхийн буруутай үйлдлээс үүдэн үйлчлүүлэгчид их хэмжээний хохирол учрахаас хамгаалдаг байна.

[21] Япон. Certified public tax accountant act (1951 [2021]). Хандах: https://www.nichizeiren.or.jp/eng/pdf/Zeirishi_Act.pdf https://hourei.net/law/326AC1000000237?

[22] Солонгос. Certified public tax accountant act (1961 [2021]). Хандах: https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=61428&type=part&key=20#:~:text=CHAPTER%20I%20GENERAL%20PROVISIONS

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Энэхүү судалгаагаар АНУ, Герман, Чех, Япон, Солонгос улсуудын татварын зөвлөх үйлчилгээний эрх зүйн орчныг татварын зөвлөхийн эрхийн зохицуулалт, хяналтын тогтолцооны хүрээнд харьцуулан судаллаа.

Татварын зөвлөх үйлчилгээний эрх зүйн үндсийг судлан үзэхэд Герман, Чех, Япон, Солонгос улсууд бие даасан хуультай, тус үйлчилгээг үзүүлэхэд тусгай эрх шаарддаг илүү төвлөрсөн тогтолцоотой. Харин АНУ-д Сангийн яамнаас баталсан журмын хүрээнд татварын зөвлөх үйлчилгээ үзүүлж буй мэргэжилтнүүдийн үйл ажиллагааг зохицуулдаг. АНУ-ын хувьд улс даяар тогтоосон татварын мэргэжлийн тусгай эрх шаарддаггүй бөгөөд Дотоод орлогын албанд татварын асуудлаар төлөөлөх эрх бүхий бүртгэгдсэн төлөөлөгч, хуульч, мэргэшсэн нягтлан бодогч зэрэг мэргэжилтнүүд татварын зөвлөх үйлчилгээг үзүүлж байна.

Харин татварын зөвлөх үйлчилгээ үзүүлэхэд тусгай эрх шаарддаг улс орнуудын мэргэшлийн шалгалт, тавигдах шаардлага, эрх олгох процессыг харьцуулан үзэхэд улс орнуудад нийтлэrttj мэргэжлийн болон, ажлын туршлагын шаардлага тавигдаж байна. Тухайлбал, дийлэнх улс мэргэжлийн шаардлагын хувьд эдийн засагч, эрх зүйч мэргэжлээр их дээд сургууль төгссөн байх шаардлага тавьдаг бол ажлын туршлагын хувьд татварын алба, төрийн байгууллагад тодорхой хугацаанд ажилласан байх шаардлага тавьдаг. Мөн зарим улсад ажлын туршлагын болон мэргэшлийн шаардлага хангасан иргэдийг шалгалтаас хэсэгчлэн болон бүрэн чөлөөлөх зохицуулалттай байна. Солонгос улсын хувьд мэргэшлийн шалгалт тэнцсэн ч заавал мэргэшүүлэх сургалт болон мэргэжлийн дадлага хийхийг шаарддагаараа онцлог байна.

Татварын зөвлөх үйлчилгээний хяналтын тогтолцооны хувьд АНУ төр болон мэргэжлийн холбоодын хосолсон тогтолцоотой бол бусад улс мэргэжлийн танхим, холбоо давамгайлсан, төрөөс эрх шилжүүлж авсан хяналтын загвар хэрэгжүүлдэг.

Тухайн улс бүрийн хууль тогтоомж, дүрэм журмаар татварын зөвлөхүүдийн үүрэг хариуцлага, мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ, хязгаарлалтыг тогтоосон байдаг бөгөөд зөрчил үүссэн тохиолдолд холбогдох хяналт хэрэгжүүлэх байгууллагаас хяналт шалгалт хийж, зөрчлийн хэмжээг тодорхойлон сахилгын шийтгэлийн төрлүүдээс ногдуулдаг байна. Улс орнууд нийтлэг сануулах, торгох, зөвлөх эрхийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох гэх мэт сахилгын шийтгэлийн төрлүүдийг ашигладаг байна.

НОМ ЗҮЙ

AOTCA. (2025). *Japan Federation of Certified Public Tax Accountants' Associations*. Хандах: https://aotca.org/article/17/3.html . Хандсан огноо: 2025-10-02

German Federal Chamber of Tax Advisers. (2023). *TAX PROFESSIONS IN EUROPE*. Хандах: https://etaf.tax/wp-content/uploads/2023/03/Tax-Professions-in-Europe_EN.pdf . Хандсан огноо: 2025-10-03

BCLP. (2013). *New proposed regulations change the requirements of Circular 230*. Хандах:https://www.lexology.com/library/detail.aspx?g=434b7a23-a322-4bfd-a449-d1d6522fbd53 . Хандсан огноо: 2025-10-03

IRS. (2025). *PTIN requirements for tax return preparers*. Хандах: https://www.irs.gov/tax-professionals/ptin-requirements-for-tax-return-preparers . Хандсан огноо: 2025-10-10

AOTCA. (2025). *Japan Federation of Certified Public Tax Accountants' Associations*. Хандах: https://aotca.org/article/17/3.html . Хандсан огноо: 2025-10-08

European Parliament. (2022). *Regulation of intermediaries, including tax advisers, in the EU/Member States and best practices from inside and outside the EU.* Хандах: https://www.europarl.europa.eu/RegData/etudes/STUD/2022/733965/IPOL_STU(2022)733965_EN.pdf . Хандсан огноо: 2025-10-06

BStBK. (2025). *Tax advisor chambers*. Хандах: https://www.bstbk.de/de/ueber-uns/steuerberaterkammern . Хандсан огноо: 2025-10-01

Treasury Department. (2014). *Regulations Governing Practice before the Internal Revenue Dervice.* Хандах: https://www.irs.gov/pub/irs-pdf/pcir230.pdf . Хандсан огноо: 2025-10-14

National Taxpayer Advocate. (2024). *Authorize the IRS to Establish Minimum Competency Standards for Federal Tax Return Preparers and Revoke the Identification Numbers of Sanctioned Preparers*. Хандах: https://www.taxpayeradvocate.irs.gov/wp-content/uploads/2024/01/ARC23_PurpleBook_02_ImproveFiling_4.pdf . Хандсан огноо: 2025-10-13